



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ХАРХОРИН СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2025 оны 04 сарын 23 өдөр

Дугаар А/77

Хархорин сум

**Гамшгаас хамгаалах болон гал түймэртэй
тэмцэх сайн дурын хэсэг
байгуулах тухай**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.7, 32 дугаар зүйлийн 32.1.2, Галын аюулгүй байдлын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.1 дэх заалт, Монгол Улсын Шадар Сайдын 2018 оны 03 дугаар сарын 13-ны өдрийн А/24 тоот тушаалыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1. Гамшгаас хамгаалах болон гал түймэртэй тэмцэх сайн дурын хэсгийн бүрэлдэхүүнийг хавсралтаар баталсугай.

2. Объектын болон ой, хээрийн түймрээс урьдчилан сэргийлэх, гал түймрийг унтраах чиг үүргийг орон нутгийн хэмжээнд хэрэгжүүлж, ажиллахыг сайн дурын хэсэг (Д.Батчулуун) -т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА  Б.БАТ-ЭРДЭНЭ

